ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Дорнод аймгийн Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДОА-2026/022/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дорнод аймаг<br>2026 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Нармандах<br>Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК<br>Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг<br>Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг. 21000
Утас: 7058-4203

2026.02.25 № 222/

танай ____________-ны № ______________-т

ДОРНОД АЙМГИЙН
БАЯН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Л.БЯМБАДОРЖ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Баян-Уул сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.2-т "Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газраас нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтоох бөгөөд нийслэлийн Засаг даргын тамгын газар нь газар, хэлтэс, тасагтай, аймаг, сум, дүүргийн Засаг даргын тамгын газар нь хэлтэс, тасагтай байна", Засгийн газрын 267 тогтоолоор "Хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, үйлчлэх өрх, аж ахуйн нэгж, байгууллагын тоог харгалзан сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг 1500 хүртэл хүн

2126050010

амтай суманд 13, 1501-3000 хүртэл хүн амтай суманд 15, 3001-5000 хүртэл хүн амтай суманд 16, 5001-10000 хүртэл хүн амтай суманд 18, 10001-20000 хүртэл хүн амтай суманд 21, 20001-ээс дээш хүн амтай суманд 23 байхаар тус тус тогтоосугай"- гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

**Бусад асуудлын хэсэг**

Дорнод аймгийн Баян-Уул сумын ЗДТГ нь 2025 онд 4 зорилт, 79 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний биелэлтийг "Хангалттай" буюу 89.7 хувиар үнэлүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **175,208,511.51** | **172,488,111.51** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 175,208,511.51 | 172,488,111.51 |
| **354** | **Хангамжийн материал** | 90,727,091.51 | 88,006,691.51 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 469,000.00 | 469,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 90,043,591.51 | 87,323,191.51 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 214,500.00 | 214,500.00 |
| 35600 | Мал амьтад | 84,481,420.00 | 84,481,420.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **6,612,885,365.94** | **6,384,724,024.31** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 6,612,885,365.94 | 6,384,724,024.31 |
| **392** | **Биет хөрөнгө** | 6,466,683,990.94 | 6,238,710,149.31 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,307,874,766.84 | 1,347,874,766.84 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (376,541,177.50) | (421,325,713.17) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 155,950,000.00 | 310,950,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (125,482,221.68) | (138,153,332.60) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 220,370,091.00 | 228,115,071.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (72,226,533.96) | (110,386,421.49) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 78,972,787.33 | 78,972,787.33 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (36,055,612.63) | (42,935,321.82) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 6,721,296,761.00 | 6,958,142,737.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (1,543,474,869.46) | (1,972,544,423.78) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 146,201,375.00 | 146,013,875.00 |
| 39301 | Програм хангамж | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (515,625.00) | (703,125.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 145,217,000.00 | 145,217,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **6,788,093,877.45** | **6,557,212,135.82** |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **6,788,093,877.45** | **6,557,212,135.82** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 6,788,093,877.45 | 6,557,212,135.82 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 827,961,716.37 | 827,961,716.37 |
| 51101 | Өмч: - төрийн | 827,961,716.37 | 827,961,716.37 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 5,840,944,325.35 | 5,610,062,583.72 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 5,733,201,391.61 | 5,840,944,325.35 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 107,742,933.74 | (230,881,741.63) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 119,187,835.73 | 119,187,835.73 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **6,788,093,877.45** | **6,557,212,135.82** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,978,735,374.57** | **1,848,191,691.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **617,198,492.00** | **413,641,156.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 617,198,492.00 | 413,641,156.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 600,000.00 | 600,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000.00 | 600,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 582,938,492.00 | 413,041,156.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,361,536,882.57** | **1,434,550,535.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 13,621,782.57 | 11,620,535.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 13,621,782.57 | 11,620,535.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,347,915,100.00 | 1,422,930,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,347,915,100.00 | 1,422,930,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,859,567,887.91** | **1,943,073,432.63** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,859,567,887.91** | **1,943,073,432.63** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,777,077,822.83 | 1,860,782,336.10 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 797,776,454.50 | 937,622,876.70 |
| 210101 | Үндсэн цалин | 453,271,427.60 | 479,932,110.70 |
| 210102 | Нэмэгдэл | 308,403,049.90 | 421,164,523.00 |
| 210104 | Урамшуулал | 36,101,977.00 | 36,526,243.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 101,697,977.32 | 117,373,933.47 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 69,425,701.32 | 79,795,379.47 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,153,299.00 | 9,394,314.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,260,907.00 | 4,776,749.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,780,169.00 | 4,681,499.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,077,901.00 | 18,725,992.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 108,369,168.10 | 121,072,357.30 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 31,028,288.93 | 26,263,717.30 |
| 210302 | Түлш, халаалт | 77,140,879.17 | 94,808,640.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 65,400,328.80 | 27,941,058.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,557,700.00 | 4,295,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,571,260.57 | 16,151,458.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,314,220.00 | 2,047,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,349,100.00 | 1,586,600.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 36,308,048.23 | 3,860,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 480,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 480,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,373,000.00 | 14,986,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,373,000.00 | 14,986,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 19,321,600.00 | 13,600,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 19,321,600.00 | 13,600,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,558,852.00 | 3,079,378.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 715,560.00 | 720,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 569,288.00 | 333,148.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 400,000.00 | 224,020.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,065,000.00 | 1,120,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 809,004.00 | 682,210.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 673,580,442.11 | 624,625,832.63 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 175,196,485.00 | 87,633,535.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 5,240,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 498,383,957.11 | 531,752,297.63 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 82,490,065.08 | 82,291,096.53 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 36,993,556.00 | 41,582,464.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 34,030,464.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 34,493,556.00 | 7,552,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 45,496,509.08 | 40,708,632.53 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 45,496,509.08 | 40,708,632.53 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **119,167,486.66** | **(94,881,741.63)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 11,424,552.92 | 136,000,000.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 11,424,552.92 | 136,000,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (11,424,552.92) | (136,000,000.00) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **107,742,933.74** | **(230,881,741.63)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,362,136,882.57** | **1,435,150,535.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **600,000.00** | **600,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 600,000.00 | 600,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 600,000.00 | 600,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000.00 | 600,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,361,536,882.57** | **1,434,550,535.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 13,621,782.57 | 11,620,535.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 13,621,782.57 | 11,620,535.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,347,915,100.00 | 1,422,930,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,347,915,100.00 | 1,422,930,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,342,136,882.57** | **1,415,150,535.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,342,136,882.57** | **1,415,150,535.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,259,646,817.49** | **1,332,859,438.47** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 797,776,454.50 | 937,622,876.70 |
| 210101 | Үндсэн цалин | 453,271,427.60 | 479,932,110.70 |
| 210102 | Нэмэгдэл | 308,403,049.90 | 421,164,523.00 |
| 210104 | Урамшуулал | 36,101,977.00 | 36,526,243.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 101,697,977.32 | 117,373,933.47 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 69,425,701.32 | 79,795,379.47 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,153,299.00 | 9,394,314.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,260,907.00 | 4,776,749.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,780,169.00 | 4,681,499.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,077,901.00 | 18,725,992.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 108,369,168.10 | 121,072,357.30 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 31,028,288.93 | 26,263,717.30 |
| 210302 | Түлш, халаалт | 77,140,879.17 | 94,808,640.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 200,000.00 | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 29,092,280.57 | 24,081,058.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,557,700.00 | 4,295,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,571,260.57 | 16,151,458.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,314,220.00 | 2,047,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 300,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,349,100.00 | 1,586,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 480,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 480,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,700,000.00 | 21,987,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 7,000,800.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 327,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 7,373,000.00 | 14,986,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 19,321,600.00 | 13,600,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 19,321,600.00 | 13,600,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | - | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,558,852.00 | 3,079,378.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 715,560.00 | 720,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 569,288.00 | 333,148.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 400,000.00 | 224,020.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,065,000.00 | 1,120,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 809,004.00 | 682,210.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 192,130,485.00 | 93,562,135.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 192,130,485.00 | 88,322,135.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 5,240,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **82,490,065.08** | **82,291,096.53** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 36,993,556.00 | 41,582,464.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,500,000.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 34,030,464.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 34,493,556.00 | 7,552,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 45,496,509.08 | 40,708,632.53 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 45,496,509.08 | 40,708,632.53 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **20,000,000.00** | **20,000,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **20,000,000.00** | **20,000,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **20,000,000.00** | **20,000,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 20,000,000.00 | 20,000,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 20,000,000.00 | 20,000,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(20,000,000.00)** | **(20,000,000.00)** |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/төгрөгөөр/**

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 824,383,716.37 | 119,187,835.73 | 5,744,081,391.57 | 6,687,652,943.67 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (10,879,999.96) | (10,879,999.96) |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **824,383,716.37** | **119,187,835.73** | **5,733,201,391.61** | 6,676,772,943.71 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 3,578,000.00 | - | - | 3,578,000.00 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 107,742,933.74 | 107,742,933.74 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **827,961,716.37** | **119,187,835.73** | **5,840,944,325.35** | 6,788,093,877.45 |
| **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **827,961,716.37** | **119,187,835.73** | **5,840,944,325.35** | 6,788,093,877.45 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **827,961,716.37** | **119,187,835.73** | **5,840,944,325.35** | 6,788,093,877.45 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (230,881,741.63) | (230,881,741.63) |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **827,961,716.37** | **119,187,835.73** | **5,610,062,583.72** | 6,557,212,135.82 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/төгрөгөөр/**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **11000** | **Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл** | **-** | **-** | **-** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,466,747,300.00** | **1,435,150,535.00** | **31,596,765.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,466,747,300.00** | **1,435,150,535.00** | **31,596,765.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,446,747,300.00** | **1,374,441,902.47** | **31,596,765.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **954,874,300.00** | **937,622,876.70** | **17,251,423.30** |
| 210101 | Үндсэн цалин | 492,694,500.00 | 479,932,110.70 | 12,762,389.30 |
| 210102 | Нэмэгдэл | 416,830,200.00 | 421,164,523.00 | -4,334,323.00 |
| 210104 | Урамшуулал | 45,349,600.00 | 36,526,243.00 | 8,823,357.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **119,360,400.00** | **117,373,933.47** | **1,986,466.53** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 81,164,900.00 | 79,795,379.47 | 1,369,520.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,549,200.00 | 9,394,314.00 | 154,886.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,774,500.00 | 4,776,749.00 | -2,249.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,774,500.00 | 4,681,499.00 | 93,001.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,097,300.00 | 18,725,992.00 | 371,308.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **128,908,700.00** | **121,072,357.30** | **7,836,342.70** |
| 210301 | Гэрэл,цахилгаан | 33,500,000.00 | 26,263,717.30 | 7,236,282.70 |
| 210302 | Түлш, халаалт | 94,808,700.00 | 94,808,640.00 | 60.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 600,000.00 | 0.00 | 600,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **29,166,900.00** | **24,081,058.00** | **5,085,842.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,916,900.00 | 4,295,800.00 | 1,621,100.00 |
| 210402 | Тээвэр,шатахуун | 15,650,000.00 | 16,151,458.00 | -501,458.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,400,000.00 | 2,047,200.00 | 352,800.00 |
| 210404 | Хог хаягдал зайлуулах,хортон мэрэгчдийн устгал,ариутгал | 300,000.00 | - | 300,000.00 |
| 210406 | Бага үнэтэй,түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,900,000.00 | 1,586,600.00 | 3,313,400.00 |
| **2105** | **Нормативд зардал** | **-** | **480,000.00** | **-480,000.00** |
| 210502 | Хоол хүнс | - | 480,000.00 | -480,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **30,730,600.00** | **21,987,700.00** | **8,742,900.00** |
| 210601 | Багаж ,техник,хэрэгсэл | 13,365,400.00 | 7,000,800.00 | 6,364,600.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 500,000.00 | 0.00 | 500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 16,865,200.00 | 14,986,900.00 | 1,878,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **14,600,000.00** | **13,600,000.00** | **1,000,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 14,600,000.00 | 13,600,000.00 | 1,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **6,416,600.00** | **3,079,378.00** | **3,337,222.00** |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 720,000.00 | 720,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 600,000.00 | 333,148.00 | 266,852.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 400,000.00 | 224,020.00 | 175,980.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,846,600.00 | 1,120,000.00 | 2,726,600.00 |
| 210807 | Газрын төлбөр | 850,000.00 | 682,210.00 | 167,790.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **119,138,000.00** | **93,562,135.00** | **25,575,865.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 113,829,100.00 | 88,322,135.00 | 25,506,965.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,308,900.00 | 5,240,000.00 | 68,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **43,551,800.00** | **41,582,464.00** | **1,969,336.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 43,551,800.00 | 41,582,464.00 | 1,969,336.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 34,030,500.00 | 34,030,464.00 | 36.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг | 7,552,000.00 | 7,552,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,969,300.00 | - | 1,969,300.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **40,708,632.53** | **(40,708,632.5)** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 40,708,632.53 | (40,708,632.53) |
| **22** | **Хөрөнгийн зардал** | **20,000,000.00** | **20,000,000.00** | **-** |
| **223** | **Бусад хөрөнгө** | 20,000,000.00 | 20,000,000.00 | - |
| 223001 | Бусад хөрөнгө | 20,000,000.00 | 20,000,000.00 | - |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,467,347,300.00** | **1,435,150,535.00** | **32,196,765.00** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,466,747,300.00** | **1,422,930,000.00** | **43,817,300.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,466,747,300.00 | 1,422,930,000.00 | 43,817,300.00 |
| | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **600,000.00** | **600,000.00** | **-** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000.00 | 600,000.00 | - |
| | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | - | | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | **11,620,535.00** | **(11,620,535.00)** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 11,620,535.00 | (11,620,535.00) |

## 2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/төгрөгөөр/**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **53,660,400.00** | **50,471,343.92** | **3,189,056.08** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **53,660,400.00** | **50,471,343.92** | **3,189,056.08** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **53,660,400.00** | **50,471,343.92** | **3,189,056.08** |
| **2103** | **БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ** | **50,660,400.00** | **47,471,343.92** | **3,189,056.08** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,085,600.00 | 16,392,298.73 | (2,306,698.73) |
| 21302 | Түлш халаалт | 21,407,000.00 | 20,832,359.19 | 574,640.81 |
| 21303 | Цэвэр, бохир ус | 15,167,800.00 | 10,246,686.00 | 4,921,114.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **53,660,400.00** | **50,471,343.92** | **3,189,056.08** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **53,660,400.00** | **50,471,343.92** | **3,189,056.08** |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 53,660,400.00 | 50,471,343.92 | 3,189,056.08 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 18.8 сая төгрөгийн 3 алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулах бичилт хийлгэж завсрын аудитын явцад залруулсан.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

*Залруулсан алдаа:*

- Үндсэн хөрөнгийн шинжийг агуулсан 13.8 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн нь “УСНББОУС 1 *Санхүүгийн тайлагналын толилуулга*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "*Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*", *“Санхүүгийн тайлангийн толилуулга”* батламж мэдэгдлийг хангаагүй тул аудитын явцад санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгө дансанд бүртгэж залруулав.
- Бараа материал дансанд бүртгэлтэй 4.1 сая төгрөгийн бараа материалын ангиллыг өөрчилж залруулав. Энэ нь “УСНББОУС 1 *Санхүүгийн тайлагналын толилуулга*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "*Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*", *“Санхүүгийн тайлангийн толилуулга”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Цалин нийт зардал, нийгмийн даатгал, ХХОАТ-ын тайлангийн тайлагнасан дүнг 0.8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн “20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шалгуур журмын 4.1.3-т “Хүчин төгөлдөр анхан шатны баримтыг үндэслэн Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар, журам болон УСНББОУС-ын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөх” 4.1.5.Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үндэслэн батлагдсан төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулж, төрийн өмч, төсвийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх” гэсэнтэй нийцэхгүй байна.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 4,300.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 15,129.8 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өгөв.

Аудитаар нийт 4.3 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс 4.3 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгөв.

### 5.1 Албан шаардлага

1. Зардлыг анхан шатны баримттай тулгахад шатахууны зардлыг дээд шатны байгууллагаас баталсан жишиг нормтой тулган хяналт хийгээгүй, зардлыг хэтрүүлэн 3,545,781 төгрөгийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах",

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Зам, тээвэр хөгжлийн яамны 2019 оны 390 дүгээр "Жишиг норм батлах тухай" тушаалын 1 дүгээр хавсралт "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-д заасантай нийцэхгүй байна.

2. Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн Г.Дуламсүрэнд 5 жилийн тэтгэмж 7,552,000 төгрөгийг олгосон ба ХХОАТ-ын 10% болох 755,200 төгрөгийг суутгаагүй нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.*Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно:* 6.3.1.цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 7 дугаар зүйлийн 7.1.*Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна:* 7.1.1.*ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого: 25.6.Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 25.2-т зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ.* Татварын ерөнхий хуулийн *6.1.19."суутган төлөгч" гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг" хэлнэ* гэж заасантай нийцэхгүй байна.

### 5.2 Зөвлөмж

*Хууль, тогтоолын хэрэгжилттэй холбоотой асуудал*

<u>*Илрүүлэлт:*</u> Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.2-т "Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газраас нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтоох бөгөөд нийслэлийн Засаг даргын тамгын газар нь газар, хэлтэс, тасагтай, аймаг, сум, дүүргийн Засаг даргын тамгын газар нь хэлтэс, тасагтай байна", Засгийн газрын 267 тогтоолоор "Хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, үйлчлэх өрх, аж ахуйн нэгж, байгууллагын тоог харгалзан сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг 1500 хүртэл хүн амтай суманд 13, 1501-3000 хүртэл хүн амтай суманд 15, 3001-5000 хүртэл хүн амтай суманд 16, 5001-10000 хүртэл хүн амтай суманд 18, 10001-20000 хүртэл хүн амтай суманд 21, 20001-ээс дээш хүн амтай суманд 23 байхаар тус тус тогтоосугай" гэсэнтэй нийцэхгүй байна. УИХ-ын 48 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдыг чадавхжуулах, чиг үүргийн давхардлыг арилгахад чиглэгдсэнд арга хэмжээ авч ажиллаагүй байна.

<u>*Өгсөн зөвлөмж:*</u> Тогтоолын хэрэгжилтийг хангаж чиг үүргийн давхардлыг арилгаж ажиллах;

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | | Зөвлөмж |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үндсэн хөрөнгийн шинжийг агуулсан хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн | 1 | 13,876.9 | | | | | 1 | 13,876.9 | | | | |
| Бараа материалын ангилал зөрүүтэй бүртгэлийг зассан | 1 | 4,088.0 | | | | | 1 | 4,088.0 | | | | |
| Цалин, НД, ХХОАТ-ын тайлангийн зөрүү | 1 | 841.1 | | | | | 1 | 841.1 | | | | |
| **Дүн** | **3** | **18,806.1** | | | | | **3** | **18,806.1** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Шатахууныг норм, норматив хэтрүүлэн олгосон | 1 | 3,545.8 | | | 1 | 3,545.8 | | | | | | |
| 5 жилийн олгосон тэтгэмжээс ХХОАТ суутгаагүй | 1 | 755.2 | | | 1 | 755.2 | | | | | | |
| **Дүн** | **2** | **4,300.9** | | | **2** | **4.300.9** | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| УИХ-ын 48 дугаар тогтоолын хэрэгжилт | | | | | | | | |
| ЗГ-ын 2009 оны 13 дугаар "Сумын засаг даргын тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоох тухай" тогтоолоор хүн амын тооноос үндэслэн орон тооны хязгаарыг тогтоодог ба 2025 оны байдлаар 3062 хүн амтай /3001-5000/ учир жишиг нормын дагуу 16 хүний орон тоотой байхаар байна. ЗД-ын 2025.01.13-ны өдрийн А/01 тушаалаар нийт 24 орон тоотой байхаар баталсан байна. Тайлант хугацаанд УИХ-ын 2025 оны 48 дугаар тогтоолоор "...багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах..." арга хэмжээг авч ажиллаагүй. | 1 | - | | | 1 | - | | |
| **Нийт дүн** | **1** | **-** | | | **1** | **-** | | |